



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 36

Есөнбулаг сум

Бугат, Төгрөг сумын Асгат нэртэй талбайд ашигт
малтмалын хайгуулын лиценз хүссэн
өргөдөлд санал өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4, 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бугат, Төгрөг сумын нутаг Асгат нэртэй талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын талбай нь орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг тул хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт явуулахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс дэмжихгүй байгааг үүгээр уламжилсугай.

2. Уг шийдвэрийг холбогдох материалын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ